



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 23 өдөр

Лугаар /23

Есөнбулаг

Дэмжлэг олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 04 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, "Шинэ сэргэлтийн бодлого" зорилт, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах, 2024 оны орон нутгийн төсөвт малчид, иргэдийн санал авах, цаг үеийн мэдээ мэдээллийг танилцуулах, төрийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор сум, багуудад зохион байгуулсан уулзалт, арга хэмжээг хамтран зохион байгуулсан байгууллагуудаас гарсан зардлыг хавсралтаар баталж олгосугай.

2. Зардалд шаардагдах 53.458.000 (Тавин гурван сая дөрвөн зуун тавин найман мянга) төгрөгийг хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2024 оны
1 дүгээр сарын 23-ны өдрийн 4/33 дугаар
захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

№	Байгууллагын нэрс	Олгох дүн
1	Аймгийн Засаг даргын тамгын газар	11.162.000
2	Соёл, урлагийн газар	2.048.000
3	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	1.472.000
4	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	2.368.000
5	Улсын бүртгэлийн хэлтэс	704.000
6	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар	768.000
7	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс	320.000
8	Ардын дуу, бүжгийн Алтай чуулга	7.552.000
9	Нийтийн номын сан	2.048.000
10	Нэгдсэн эмнэлэг	9.920.000
11	Нийтлэг үйлчилгээ УТҮГ	3.840.000
12	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар	2.176.000
13	Нийгмийн даатгалын хэлтэс	1.480.000
14	Инноваци, судалгаа, бизнес хөгжлийн төв	3.320.000
15	Зоонозын өвчин судлалын төв	1.720.000
16	Хэвлэл мэдээллийн байгууллага	2.560.000
	Нийт	53.458.000

__оОо__